

**БНХАУ-ын Бээжин хотод олон улсын
"Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх"
сургалтанд хамрагдсан товч тайлан**

2016.11.29

Нислэгийн цаг уурын төвийн Буянт-Ухаа станцын инженер Ү.Отгонсүрэн БНХАУ-ын Бээжин хотноо 2016 оны 10 дугаар сарын 10-наас 21-ний өдрүүдэд Хятадын Цаг уурын алба болон Үндэсний хөгжлийн шинэчлэлийн хороотой хамтран Өмнөдийн хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр зохион байгуулж байгаа "Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлын талаарх" олон улсын сургалтанд хамрагдсан.

Энэхүү олон улсын сургалт, курсын зорилго нь :

Манай гариг дээр уур амьсгалын ямар, ямар өөрчлөлтүүд ажиглагдаж байгаа болон эдгээр нь юунаас болоод байна вэ, энэ нөлөөлөлд хүний хүчин зүйлийн нөлөөлөл байгааг таниж мэдэхэд туслах зорилготой.

Сургалтаар Хятадын цаг уурын байгууллага, тус байгууллагын сургалтын төвийн талаар болон Хятад улсад хэрэглэгдэж буй цаг уурын системийн талаар товч танилцуулга, БНХАУ уур амьсгалын өөрчлөлтэй хэрхэн тэмцэж байгаа, энэ асуудлаар олон арга хэмжээ авч явуулж байгаа болон уур амьсгалын өөрчлөлтөнд маш их хувь нэмрээ оруулж байгаа талаар багш нар танилцуулсан. Мөн тус улсын засгийн газар энэ салбартаа маш их анхаарал хандуулдаг, дэмждэг мөн түүнчлэн хөрөнгө оруулалт хийдэг, тенжик технологиор дэмждэг талаар танилцуулсан.

Тус сургалтанд нийт 14 улсын 26 оролцогчид оролцсон бөгөөд сургалтын хугацаанд нийт 14 лекц сонсож, тус улсын Цаг уурын ажиглалтын 2 станц дээр очиж танилцсан.

Дүгнэлт:

Нэгдүгээрт: Одоо манай гариг дээр уур амьсгалын ямар, ямар өөрчлөлтүүд ажиглагдаад байгаа вэ, эдгээр нь юунаас болоод байна вэ, энэ нөлөөлөлд 95% хүний хүчин зүйлийн нөлөөлөл байна гэдгийг,

Хоёрдугаарт: Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөлөлд ямар, ямар секторууд автах вэ, тэдгээрийн эдийн засгийн болон эрсдлийн үнэлгээг одоо болон ирээдүйн тооцоо судалгааны талаар,

Гуравдугаарт: Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, түүнд хэрхэн дасан зохицох, үүнтэй холбоотойгоор хэрхэн цаашид тогтвортой хөгжих вэ зэрэг үндсэн 3 ойлголтыг авсан.

Тайлан бичсэн:

НЦУТ-Буянт-Ухаа станцын инженер

Ү.Отгонсүрэн

